
	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн <i>А.Т.О.В.</i> тоот тушаалын долдугаар хавсралт	
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)		Баталсан огноо: 2026.01.20	Хуудасны тоо: 5
<b>Баримт бичгийг хариуцагч:</b> Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан		<b>Танилцах албан тушаалтнууд:</b> Мэргэжлийн багш нар	

ШТА 1050 1124090015 0020014

## “СУДАЛГАА, ИННОВАЦЫН ” ЖУРАМ

### Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:  
Хувилбарын дугаар: V1.2026

### Түгээлт




Энэ журам нь манай байгууллагын өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ журмын батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

### ЗӨВШӨӨРӨЛ

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү журмыг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
Боловсруулсан	Ерөнхий эрдэм хариуцсан Арга зүйч	Гантөмөр Өлзиймөнх	2026.01.16	
Хянасан	Сургалтын менежер	Лувсандорж Чингэрэл	2026.01.19	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.01.20	

## НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмын өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт журамд орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

## АГУУЛГА

НЭГ.Нийтлэг үндэслэл.....	1
ХОЁР.Зорилго.....	1
ГУРАВ. Удирдлага зохион байгуулалт.....	1
ДӨРӨВ. Инновацын үйл ажиллагаа.....	2-3
ТАВ.Инновацын бүтээгдэхүүн.....	3-4
ЗУРГАА. Санхүүжилт, түүнд тавигдах шаардлага.....	4
ДОЛОО. Инновацийн бүтээгдэхүүний оюуны өмчийг хамгаалах, эзэмших, ашиглах.....	4-5
НАЙМ. Бүртгэл маягт.....	5-6
ЁС. Бусад зүйл.....	5



№ Ж-3-011

“Судалгаа, инновацын” журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Зөвхөн дотоод хэрэгцээнд- Нээлттэй

## Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журам нь Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Өмнөговь политехник коллеж (Цаашид ПК гэж товчилно)-ийн дотоод дүрэм, журмын хүрээнд ПК-д цахим судалгаа, инновац түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Инновацын тухай хууль, төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого, ПК-ийн стратеги төлөвлөгөө, холбогдох дүрэм, журам, эрх зүйн бусад актын хүрээнд үйлчилнэ.

## Хоёр.Зорилго

2.1.ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь ТДС-ийн харьяа Политехник коллеж (цаашид “сургууль” гэх)-ийн сургалт, судалгаа төсөлт ажлыг дэмжин оюуны бүтээгдэхүүн бий болгох, хөгжүүлэх, инновацын төсөл боловсруулах, санхүүжүүлэх, оюуны өмч эзэмших, ашиглах, захиран зарцуулах, зохиогч зохион бүтээгчдийг урамшуулахтай холбоотой инновацын үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдэнэ.

## Гурав.Удирдлага зохион байгуулалт

3.1.Тус сургууль нь инновацын бодлого боловсруулах, инновацын үйл ажиллагааг төлөвлөх, хянах, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий нэгж эсвэл орон тооны бус зөвлөлтэй байх бөгөөд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- 3.1.1.инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;
- 3.1.2.инновацын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, түүнд хяналт тавих;
- 3.1.3.инновацын нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
- 3.1.4.инновацын үйл ажиллагааг урамшуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;



№ Ж-3-011

“Судалгаа, инновацын” журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Зөвхөн дотоод хэрэгцээнд- Нээлттэй

## Дөрөв.Инновацын үйл ажиллагаа

### 4.1.Дараах үйл ажиллагааг инновацын үйл ажиллагаанд тооцно.

4.1.1.шинэ мэдлэг бий болгох зорилго бүхий сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг;

4.1.2.оюуны бүтээгдэхүүн бий болгох зорилго бүхий сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлыг;

4.1.3.оюуны өмчөөр баталгаажсан, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд түгээн дэлгэрүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой бүх төрлийн үйл ажиллагааг;

4.1.4.оюуны өмч түүнчлэн зохиогчын эрхийг хамгаалах эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой үйл ажиллагааг;

4.1.5.шинэ мэдлэг, оюуны өмчөөр баталгаажсан инновацын бүтээгдэхүүний зохиогч, зохион бүтээгчдийг шагнах, урамшуулахтай холбоотой инновацын үйл ажиллагааг;

### 4.2.Инновацын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.2.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчин сөрөг нөлөө үзүүлэх инновацын үйл ажиллагаа явуулахгүй байх;

4.2.2.нийгэм, эдийн засгийн өндөр үр ашигтай;

4.2.3.ил тод, шударга, нээлттэй байх;

4.2.4.инновацын үйл ажиллагааны үндэслэл бүхий эрсдэлийг ӨМПК болон бусад санхүүжүүлэгч этгээд хүлээн зөвшөөрөх;

### 4.3.Инновацын үйл ажиллагааны дэмжлэг

4.3.1.инновацын үйл ажиллагаанд Инновацын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан заалтын дагуу төрөөс дэмжлэг авч болно;

4.3.2.инновацын үйл ажиллагаанд хувийн байгууллагаас дэмжлэг авч болно;

4.3.3.инновацын үйл ажиллагаанд олон улсын байгууллагаас дэмжлэг авч болно;

4.3.4.инновацын үйл ажиллагаанд гадаадын байгууллагаас дэмжлэг авч болно;

4.4.4 тэнхим, нэгжүүдээс инновацын төслийн талаарх санал авсны үндсэн дээр дараа оноос шинээр хэрэгжүүлэх инновацын үйл ажиллагааг



№ Ж-3-011

“Судалгаа, инновацийн” журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Зөвхөн дотоод хэрэгцээнд- Нээлттэй

тодорхойлж, тухайн оны 2 дугаар сарын 01-ний дотор нээлттэй зарлаж, дүгнээд, үр дүнг нь Сургалт арга зүйн зөвлөлд танилцуулна;

4.4.5.сургалт арга зүйн зөвлөлөөр хэлэлцэгдэж дэмжигдэх шаардлагатай бол Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжсэн тохиолдолд тус сургуулийн үйл ажиллагааны тайлан жилийн төлөвлөгөөнд тусгуулна;

### Тав.Инновацийн бүтээгдэхүүн

5.1.Сургалтын орчин дахь мэдлэг шингэсэн, шинэ мэдлэг бий болгосон дараах үр дүнг инновацийн бүтээлд тооцно. Үүнд:

5.1.1.талууд харилцан тохиролцсон төгсөлтийн бүтээлч ажил;

5.1.2.сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлын шинэ мэдлэг шингэсэн биет болон биет бус үр дүн;

5.1.3.сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, төсөлт ажлын оюуны өмчөөр баталгаажсан үр дүн;

5.1.4.сургалтад нэвтрүүлэх болон зах зээлд түгээх боломжтой, оюуны өмчөөр баталгаажсан, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн;

5.2.Дээрх 4.1.1 - 4.1.4-т заасан үр дүнг сургалтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, захиалгат болон төсөлт ажлын гэрээний дагуу гүйцэтгэсэн байх бөгөөд Инновацийн тухай хуулийн 15.1 дахь заасан шаардлагыг хангасан байна. Гэрээгүй тохиолдолд инновацийн бүтээгдэхүүнд тооцохгүй.

5.3.Инновацийн бүтээгдэхүүнд дараах зарчмыг баримтална. Үүнд:

5.3.1.техникийн боловсролын бүтээлч төгсөлтийн ажил нь тус сургуулийн өмч бөгөөд оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой асуудлыг сургалтын гэрээгээр зохицуулна;

5.3.2.инновацийн төсөл нь сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэлд нийцсэн, шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн дэвшилэлтэт ололтыг ашигласан байна;

5.3.3.тухайн төсөлд нийцсэн мэргэжлийн болон туршилгатай хүний нөөц бүрдүүлсэн байна;

5.3.4.тухайн төсөлд нийцсэн мэргэжлийн болон туршилгатай хүний нөөц бүрдүүлсэн байна;

5.3.5.төслийн баг нь тухайн нэгжийн ажлын ажлын өрөө, анги танхим,



№ Ж-3-011

**“Судалгаа, инновацын” журам**

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Зөвхөн дотоод хэрэгцээнд- Нээлттэй

судалгааны лаборатори, компьютер болон бусад техникийг ашиглах эсэх, захиалсан үр дүн, санхүүжилтийн тухай зохих журмын дагуу бичсэн тайланг хүлээлгэн өгөх хугацаа, тавих шаардлага, шаардлагыг хангаагүй тохиолдолд дахин гүйцэтгэх ба гүйцэтгэгчээр хөрөнгийг нөхөн төлүүлэх талаар талууд гэрээнд заавал тусгана;

### **Зургаа.Санхүүжилт, түүнд тавигдах шаардлага**

6.1.Санхүүжилтийн эх үүсвэр нь Засгийн газар, холбогдох яам, шинжлэх ухаан технологийн сан, гадаадын, орон нутгийн, сургуулийн, гэрээт ажил, хамтарсан төслийн дэмжигч байгууллага, хувь хүн гэсэн олон талт эх үүсвэртэй байж болно.

6.2.Инновацын үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийн хэмжээг жил бүр Захирлын тушаалаар батална.

6.3.Инновацын үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн зохицуулалтыг сургуульд мөрдөж буй холбогдох бусад дүрэм, журмаар зохицуулна.

### **Долоо.Инновацийн бүтээгдэхүүний оюуны өмчийг хамгаалах, эзэмших, ашиглах**

7.1.Инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийн хамгаалах, эзэмших, ашиглахтай холбогдсон асуудлыг зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Патентын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль болон оюуны өмчид хамаарах бусад хуулт тогтоомжийг мөрдлөг болгон зохицуулна.

7.2.Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглахтай холбоотой асуудлыг Инновацын тухай хуулийн 27-р зүйлд заасны дагуу зохицуулна.

7.3.Сургуулийн санхүүжилтээр, түүнчлэн сургуулиас өгсөн албан даалгавар эсвэл албан үүргийн дагуу сургуулийн технологи, төхөөрөмж, материал, мэдээлэл, туршлага зэргийг ашиглаж гүйцэтгэсэн инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийг хамгаалах, эзэмших, ашиглах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол ПК эдэлнэ.



№ Ж-3-011

“Судалгаа, инновацын” журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Зөвхөн дотоод хэрэгцээнд- Нээлттэй

7.4.Захиалгын гэрээгээр гүйцэтгэсэн инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийг хамгаалах, эзэмших, ашиглах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч эдэлнэ.

7.5.Хамтарсан төслийн хүрээнд гүйцэтгэсэн инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийг хамгаалах, эзэмших, ашиглах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол оролцогч талууд хамтарч эдэлнэ.

7.6.Гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр гүйцэтгэсэн инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийг хамгаалах, эзэмших, ашиглах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч эдэлнэ.

### **Найм.Бүртгэл маягт**

8.1.Инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон шинэ бүтээл, ашигтай загвар бүтээгдэхүүний загварын зохиогч, зохион бүтээгчдэд ажил гүйцэтгэх гэрээний дагуу зохих төлбөр төлж урамшуулна.

8.2.Ажил гүйцэтгэх гэрээнд төлбөр төлөх нөхцөл, хэмжээг тодорхой тусгах бөгөөд төлбөрийн хэмжээг тухайн оюуны өмчийн эдийн засаг, зах зээлийн үнэлгээ, ашигласнаас олгох үр ашиг, оролцогч талуудын оруулсан хувь нэмэр зэргийг харгалзан тогтооно.

### **Ес.Бусад зүйл**

9.1.Инновацын багийн гишүүд нь орон тооны бус бөгөөд ажлын үр дүнгээс хамааруулах гишүүдэд хичээлийн хичээлийн жилд нэг удаа урамшуулал өгч болно. Урамшууллын хэмжээг Захирлын тушаалаар тогтооно.